



ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ᠳᠣᠷᠨᠣᠭᠣᠪᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠨᠢᠶᠭᠦᠮ, ᠡᠳᠢᠶᠢᠨ ᠵᠠᠰᠭᠢᠨ
ᠲᠠᠨᠢᠯᠴᠠᠭᠤᠯᠠ

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

2020/02



Мэдээллийн нэгдсэн лавлах: WWW.1212.MN

ГАРЧИГ

Товч танилцуулга.....	1-14
Нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд.....	15
Нэг. Эрүүл мэнд.....	16-17
Хоёр. Хөдөлмөр эрхлэлт	18-19
Гурав. Нийгмийн даатгал, халамж.....	20-23
Дөрөв. Гэмт хэрэг.....	24-25
Тав. Мөнгө,зээл	26
Зургаа. Төсөв, санхүү	27-28
Долоо. Үнэ.....	29-32
Найм. Хөдөө аж ахуй	33-35
Ес. Аж үйлдвэр.....	36-40
Арав. Байгаль орчин	41

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

(2020 оны 02 дугаар сарын байдлаар)

Нэг. Нийгмийн үзүүлэлт




1.1 Хүн ам

Дорноговь аймгийн хэмжээнд 2020 оны 02 сард 255 эх амаржиж, 256 хүүхэд шинээр мэндэлж, 67 хүн нас барсан байна. Амаржсан эхийн тоо өмнөх оны мөн үеэс 42(19.7%)-оор, төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үес 39(18.0%)-өөр тус тус өсч, нас барсан хүний тоо өмнөх оны мөн үеэс 3(4.3%)-аар буурсан байна.

Хүн амын цэвэр өсөлт 189 болж 2019 оны мөн үеийнхээс 42(28.6%)-оор өссөн байна. 1000 хүнд ногдох төрөлт 3.6, нас баралт 1.0 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 0.5 пунктээр өсч, нас баралт өмнөх оны мөн үетэй адил хэмжээнд байна.

Зураг. Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо. 2017-2020 оны 02 сард



Он гарсаар эхийн эндэгдэл гараагүй бөгөөд нялхсын эндэгдэл 2 байна.



1.2 Эрүүл мэнд

2020 оны 02 сарын байдлаар 72.3 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 15.9 хувиар, 3.6 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 33.3 хувиар тус тус өсч, 1.7 мянган хүн урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 10.5 хувиар буурчээ.




2020 оны 02 сард 312 эх жирэмсний хяналтанд орсны 92.3 хувь буюу 288 эх жирэмсний эхний 3-н сард хяналтанд хамрагджээ. Жирэмсний хяналтанд хугацаандаа орсон эхийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 6.1 хувиар өссөн байна.

Түргэн тусламжийн дуудлага 4.7 мянган удаа гарсны 0.8 мянга буюу 17.0 хувь нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт түргэн тусламжийн дуудлага өмнөх оны мөн үеэс 14.6 хувиар, алсын дуудлага өмнөх оны мөн үеэс 33.3 хувиар тус тус өссөн байна.

Он гарсаар ослын улмаас 430 хүн бэртэж, 13 иргэний амь нас энджээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бэртэж гэмтсэн хүний тоо 86(25.0%)-аар, нас барсан хүний тоо 2(18.2%)-оор тус тус өссөн байна.

Зураг. Нас баралт, өвчний шалтгаанаар, хувь. 2020 оны 02 сард



Нас баралтыг өвчний шалтгаанаар авч үзэхэд бусад төрлийн өвчин 31.4 хувь, хавдар 22.9 хувь, цусны эргэлтийн тогтолцооны өвчин 20.0 хувь, осол гэмтэл, хордлого гадны шалтгаант үхэл 14.3 хувь, хоол шингээх эрхтний өвчин 11.4 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт өвчний 172 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 41-ээр буюу 31.3 хувиар өсчээ. Халдварт өвчний тохиолдол өсөхөд тэмбүү 74.1 хувь, трихоминиаз 61.3 хувь, заг хүйтэн 2.1 дахин өссөн нь тус тус голлон нөлөөлжээ.




1.3 Бүртгэлтэй ажилгүй иргэн

Хөдөлмөрийн хэлтэст ажил хайж бүртгүүлсэн иргэд 2020 оны 02 сарын эцэст 329 болсны 312(94.8%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 17 (5.2%) нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнөх оны мөн үеийнхээс 175(34.7%) хүнээр, өмнөх сараас 86(35.4%) хүнээр тус тус өсчээ.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн боловсролын түвшинг харахад 160(48.6%) нь бүрэн дунд, 84(25.5%) нь дээд, 30(9.1%) нь техник болон мэргэжлийн, 24(7.3%) нь бүрэн бус дунд, 23(7.1%) нь тусгай дунд, 3(0.9%) нь бага, 3(0.9%) нь боловсролгүй 2(0.6%) магистр, докторын боловсролтой иргэд эзэлж байна.

Зураг. Ажилгүй иргэдийн тоо, боловсролоор, хувиар, 2020 оны 02 сарын эцэст




Хөдөлмөрийн хэлтэст 2020 оны эхний 2 сарын байдлаар 30 иргэн шинэ ажлын байранд орж, бүртгэлтэй байсан 17 иргэн ажилд зуучлагдан орж, өмнөх сарын бүртгэлээс 30 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар хасагдсан байна.



1.4 Нийгмийн даатгал, халамж


Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2020 оны 02 сарын байдлаар 7009.7 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 182.6 (2.7%) сая төгрөгөөр өссөн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого 2020 оны 02 сард өмнөх оны мөн үеэс 182.6 сая төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгал 133.2 (3.1%) сая төгрөг, эрүүл мэндийн даатгал 18.0 (1.6%), ҮОМШӨ-ний даатгал 16. (2.2%) сая төгрөг, тэтгэмжийн даатгал 11.8 (2.4%) сая төгрөг, ажилгүйдлийн даатгал 3.6 (1.8%) сая төгрөгөөр өссөн байна.

Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого сангийн төрлөөр /сая.төг/ 2020 оны 02 сард



Нийгмийн даатгалын сангийн зарлага 9558.3 сая.төг болж өмнөх оны мөн үеэс 1078.6(12.7%) сая.төгрөгөөр өссөн байна. Зарлагыг бүтцээр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын сангаас 6957.1 (72.8%) сая.төг, эрүүл мэндийн даатгалын сангаас 1134.0 (11.9%) сая.төг, тэтгэмжийн даатгалын сангаас 758.8 (7.9%) сая.төг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 421.0 (4.4%) сая.төг, ажилгүйдлийн даатгалын сангаас 287.4 (3.0%) сая төгрөгийг зарцуулжээ.

Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сая төг







Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас 2020 оны 02 сард нийгмийн халамжийн сангаас 15920 иргэнд 523.1 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ. Өмнөх онтой харьцуулахад халамж авсан иргэд 2234(12.3%)-аар, олгосон тэтгэвэр тэтгэмж 26.0(1.4%) сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2020 оны 02 сард 1265 хүн хамрагдсан нь өмнөх оноос 235(15.7%)-аар буурч, олгосон тэтгэвэрийн хэмжээ 61.6(15.7%) сая төгрөгөөр өсчээ. Нийгмийн нөхцөлт мөнгөн тусламжийг 946 иргэнд 160.1 сая төгрөг, онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг 242 иргэнд 93.4 сая төгрөг тус тус олгож, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургахад 3526 иргэнийг хамруулж, 128.6 сая төгрөгийг зарцуулсан байна. Бусад төрлийн халамжийн үйлчилгээнд 9941 иргэн хамрагдаж, 1080.0 сая төгрөгийг олгожээ.

Зураг. Хүний тоо



Зураг. Олгосон тэтгэвэр, тэтгэмж /сая. төг/





1.5 Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр 2020 оны 2 дугаар сарын байдлаар 107 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 24 хүн гэмтэж, 4 хүн нас барсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 1(0.9%)-ээр нэмэгдэж, гэмтсэн хүний тоо 6(20.0%) -аар, нас барсан хүний тоо 5(55.6%)-аар тус тус буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 9(21.9%)-өөр, улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэрэг 14(8 дахин)-өөр, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 8 (2 дахин)-аар өсч, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 10 (90.9%)аар, хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг 15(50.0%)-аар, хүний бэлгийн эрх чөлөө, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 3(37.5%)-аар, хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 2(40.0%)-оор тус тус буурчээ.


Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сараар



Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 46.7 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 15.0 хувийг улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэрэг, 14.0 хувийг хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, 13.1 хувийг хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, 4.7 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 6.5 хувийг бусад төрлийн гэмт хэргүүд эзэлж байна. Сogтуугаар үйлдсэн гэмт хэрэг 10 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13(56.5%)-аар буурсан байна.

Гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс Айраг, Алтанширээ, Дэлгэрэх, Мандах, Өргөн сумдад нэмэгдэж, Улаанбадрах суманд гэмт хэрэг бүртгэгдээгүй, бусад сумдад гэмт хэргийн тоо буурсан байна.


Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сумаар



Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 228.7 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 29.5 (11.4%) сая төгрөгөөр буурсан байна. Учирсан хохирлын 57.2 (25.0%) сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

Нийт гэмт хэргийн 23(21.5%) нь гэр орон сууцандаа, 11(10.3%) нь гудамж олон нийтийн газарт, 10(9.3%) нь согтуугаар, 19(17.8%) бүлэглэн, 11(10.3%) хувийг эмэгтэй хүн оролцон, 37 (25.2%) нь шөнийн цагаар /22-06 цаг/ үйлдсэн байна. Тайлант хугацаанд нийт 192 хүн саатуулагдаж, 21 хүн баривчлагджээ.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, хэрэг үйлдэгдсэн цагаар 2020 оны 02 сард




Хоёр. Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт




2.1 Мөнгө, банк

Монгол банкны мэдээгээр арилжааны банкуудын зээлдэгчийн тоо 36.0 мянга болж өмнөх оноос 2.9%(1.0) мянган хүнээр нэмэгдэж, нийт хадгаламжийн данс эзэмшигчийн тоо 68.1 мянга болж өмнөх оны мөн үеээс 5.2 хувиар буурсан байна.

Зураг. Хадгаламжийн үлдэгдэл, зээлийн өрийн үлдэгдэл, 2019-2020 он, сая.төг



Зураг. Хадгаламж эзэмшигч, зээлдэгчийн тоо, 2019- 2020 он, мян.хүн




Нийт хадгаламжийн үлдэгдэл 126.7 тэрбум төгрөг болж нэг хадгаламж эзэмшигчид дунджаар 1860.8 мянган төгрөг, аймгийн нэг хүнд дундажаар 1820.7 мянган төгрөгийн хадгаламж ногдож байна. Хадгаламжийн үлдэгдэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23.3 %(23.9) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл сарын эцэст 10.8 тэр бум төгрөг болж, өмнөх сараас 2.0²(5.6) тэр бум төгрөгөөр өсч, өмнөх оны мөн үеэс 2.2² (5.9) тэр бум төгрөгөөр өсчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 4.0 хувийг эзэлж, өмнөх сараас 2.2 пунктээр өсч, өмнөх оны мөн үеэс 2.3 пунктээр өсчээ.

Чанаргүй зээл сарын эцэст 8140.6 сая төгрөг болж өмнөх сараас 19.2% (1315) сая төгрөгөөр өсч, өмнөх оны мөн үеэс 16.6%(1160.9) сая төгрөгөөр өсч байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 3.0 хувийг эзэлж өмнөх оны мөн үеэс 0.6 пунктээр өссөн байна.

Зураг. Зээл төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2020.02 сард



Зураг. Зээлдэгчийн тоо, зээлийн төрлөөр, 2020.2 сард



2.2 Төсөв, санхүү

2020 оны 02 дугаар сарын байдлаар орон нутгийн төсөвт 5251.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 63.2 хувь байна. Өмнөх оны мөн үетэй төсвийн орлогын дүнг харьцуулахад 50.2 хувиар өссөн байна. Аймгийн орон нутгийн төсвийн орлогын 71.1 хувийг татварын, 28.9 хувийг татварын бус орлого бүрдүүлсэн байна.

Зураг. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын бүтэц, хувиар, 2020 оны 02 сард



Улсын нэгдсэн төсөвт ААНБ-ын орлогын албан татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, ашигт малтмал нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр нийт 2474.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын дүнг өмнөх оны мөн үеэс 3.3 дахин 1713.1 сая.төг-өөр, төлөвлөгөөнөөс 2.3 дахин буюу 1387.0 сая.төг-өөр давуулан биелүүлсэн байна.



2.3 Үнэ

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний үнийн индекс 2020 оны 02 дугаар сарыг өмнөх сартай харьцуулахад 1.2 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 6.5 хувиар өсчээ.


Ерөнхий индекс өмнөх сартай харьцуулахад 1.2 хувиар өсөхөд: хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 3.4 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлэг 0.2 хувь, хувцас бөс бараа, гуталын бүлэг 1.1 хувь, гэр ахуйн тавилгын бүлэг 0.5 хувь, эм тариа эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 0.5 хувиар өсч, бусад бараа үйлчилгээний бүлэг тогтвортой байна.

Ерөнхий индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.5 хувиар өсөхөд: хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 11.5 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлэг 4.5 хувь, хувцас бөс бараа, гуталын бүлэг 6.3 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 6.4 хувь, гэр ахуйн тавилгын бүлэг 5.0 хувь, эм тариа эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 2.3 хувь, тээврийн бүлэг 2.1 хувь, амралт чөлөөт цаг соёлын барааны бүлэг 1.3 хувь, боловсролын үйлчилгээний бүлэг 9.9 хувь, зочид буудал, зоогийн газар, дотуур байрны үйлчилгээний бүлэг 12.3 хувь, бусад бараа үйлчилгээний үнэ 3.8 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.


Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2020 оны 02 дугаар сарын өөрчлөлт, бүлгээр, хувиар (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2019-2020 оны үнийн өөрчлөлт, сар бүрээр (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2016 -2020 оны 02 дүгээр сар (өмнөх оны 12-р сар=100)



Гурав. Эдийн засгийн статистикийн үзүүлэлт



3.1 Хөдөө аж ахуй

Аймгийн хэмжээнд 2019 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 1010.6 мянган хээлтэгч малын 5.2 мянга (0.5%) нь 2020 оны эхний 2 сард төллөсөн байна. Эм хонины 0.7 хувь, эм ямааны 0.4 хувь, ингэний 0.2 хувь, үнээний 0.7 хувь нь төллөжээ.

Гарсан төлийн 99.7 хувь буюу 5.2 мянган төл бойжиж байна. Бойжуулсан төл өмнөх оны мөн үеэс 730 (12.3%) мянгаар дутуу байна. Сайншанд суманд 2.2 мянга, Хатанбулаг суманд 1.4 мянган төл тус тус бойжсон нь нийт бойжсон төлийн 69.2 хувийг эзэлж байна.

Том малын зүй бус хорогдол 2020 оны 02 сард аймгийн хэмжээнд 80 болж, өмнөх оны мөн үеэс 78(49.0%) толгойгоор буурсан байна. Нийт хорогдсон малын 70.0 хувийг ямаа, 25.0 хувийг хонь эзэлж байна.

Малын зах зээлийн дундаж үнийн мэдээгээр нас гүйцсэн ат Алтанширээ суманд хамгийн их буюу 1500.0 мянган төгрөг, Дэлгэрэх, Сайхандулаан, Хатанбулаг, Эрдэнэ сумдад хамгийн бага буюу 1000.0 мянган төгрөг, соёолон үрээ Алтанширээ, Иххэт, Өргөн, Замын-үүд сумдад их буюу 1000.0 мянган төгрөг, Мандах, Сайхандулаан, Эрдэнэ сумдад хамгийн бага буюу 700.0 мянган төгрөг, хязаалан гуна Айраг суманд хамгийн их буюу 2000.0 мянган төгрөг, Хөвсгөл суманд хамгийн бага буюу 900.0 мянган төгрөг байна. Нас гүйцсэн эр хонины дундаж үнэ Айраг, Иххэт, Замын-Үүд суманд хамгийн их буюу 200.0 мянган төгрөг, Хатанбулаг суманд хамгийн бага буюу 120.0 мянган төгрөг, нас гүйцсэн эр ямааны дундаж үнэ Айраг, Дэлгэрэх, Замын-Үүд сумдад хамгийн их буюу 150.0 мянган төгрөг, Алтанширээ, Иххэт, Өргөн, Сайхандулаан сумдад хамгийн бага буюу 100.0 мянган төгрөг байна.



3.2 Аж үйлдвэр

Оны эхний 02 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарт 6425.6 сая төгрөг тус тус буурсан байна.

2020 оны 02 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 80.1 хувиар буурахад уул, уурхай олборлох салбарын үйлдвэрлэлт өмнөх оноос 10494.4 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 27.4 хувийг төрийн, 72.6 хувийг хувийн өмчийн аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэжээ.

Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр авч үзвэл улсын үйлдвэрийн газар 35.0 хувь, компани 62.7 хувь, өрхийн аж ахуй 2.3 хувийг тус тус эзэлж байна.

Статистикийн мэдээлэлд хамрагдсан гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дулаан 14.0 мян.ккалаар, ус түгээлт 33.2 мян.м3-аар, сувагжуулалт 16.1 мян.м3-аар, савласан цэвэр ус 56.5 мян.литрээр, талх 31.4 тонноор, нарийн боов 4.7 тонноор, хэрчсэн гурил 13.2 мян.тн-оор, банш бууз 0.7 тонноор, гутал 20 ширхгээр, шохой 2000 тонноор, модон эдлэл 3642.0 мянган төгрөгөөр, вакуум цонх 126.4 м2-аар, жижиг оёдол 236.8 мян.төгрөгөөр, хайрга 4.1 мян.м3-аар тус тус илүү үйлдвэрлэгджээ.

Дөрөв. Байгаль орчны статистикийн үзүүлэлт



4.1 Байгаль орчин

Цаг уур

Сарын дундаж агаарын температур 2 дугаар сард: Хөвсгөл, Хатанбулаг, Улаанбадрах сумдад -5.8...-6.9 градус, бусад сумдын нутгаар -7.5...-11.6 градус, агаарын хамгийн их температур өдөртөө Замын-Үүд, Хөвсгөл сумдад 11...13 градус, бусад сумдад 5...9 градус байлаа. Агаарын дундаж температурыг олон жилийн дундаж / ОЖД /-тай харьцуулахад: Нийт сумдад ОЖД-аас дулаан байлаа. Хөрсний гадарга дээр шөнөдөө -22...-30 градус, өдөртөө Алтанширээ суманд 12 градус, бусад сумдад 18...21 градус байв.

Хур тунадас: 2 дугаар сард Мандах, Сайхандулаан, Улаанбадрах сумдад 0.4...0.6 мм, бусад сумдын нутгаар 1.4...6.9 мм, хур тунадастай өдөр 3...4 байлаа. Орсон хур тунадасны нийлбэрийг олон жилийн дундаж /ОЖД/-тай харьцуулахад: Мандах, Сайхандулаан сумдад ОЖД-аас бага, Улаанбадрах суманд ОЖД-ийн орчим, бусад сумдын нутгаар ОЖД-аас ахиу цас орсон байна.



Салхи: Энэ сард салхины хамгийн их хурд Хөвсгөл суманд секундэд 18 метр, Мандах, Эрдэнэ, Алтанширээ, Иххэт сумдад 16 метр, бусад сумдын нутгаар 10-15 метр хүрсэн. 10м/с-ээс дээш салхитай хоногийн тоо 3...13 өдөр байлаа.

Цасан бүрхүүлийн байдал: 2 дугаар сарын 29-ний байдлаар Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг, Мандах, Сайхандулаан сумдад цасгүй, бусад сумдад 9-10 баллын 1-5 см цасан бүрхүүлтэй байв.

МАА-н үйлдвэрлэлд: Цаг агаарын нөхцлөөс болж малын бэлчээрлэлт саатсан тохиолдол гараагүй. Сумдын нутгаар мал төллүүлэх ажил явагдаж байна. Малын усан хангамж ихэнх нутгаар дунд зэрэг байлаа.

_____ о О о _____

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**
(2020 ОНЫ 02 ДУГААР САРЫН БАЙДЛААР)**I. Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүд**

	Хэмжих нэгж	2017	2018	2019	2020	2020 2019
1. Бэлэн хүн ам, мян.хүн *	мянган хүн	68.2	69.6	70.5	70.6	100.1
- Төрсөн хүүхдийн тоо**	тоо	189	228	217	256	118.0
- Нас барсан хүний тоо - бодит тоогоор**	тоо	49	57	70	67	95.7
- Хүн амын цэвэр өсөлт - бодит тоогоор	тоо	140	171	147	189	128.6
- Нялхасын эндэгдэл - бодит тоогоор	тоо	3	1	2	4	2.0 ²
- 1000 хүүхдэд ноогдох	тоо	15.9	4.4	9.2	15.6	169.5
2. Ажилгүй иргэдийн тоо - бүгд	тоо	1 705	1 040	504	329	65.3
- Үүнээс эмэгтэй	тоо	889	522	255	163	63.9
- Хөдөлмөрийн насны 10000 хүнд ноогдох ажилгүй иргэдийн тоо	тоо	395	237	203	71	34.9
3. Шинээр бий болсон ажлын байр-бүгд	тоо	56	3	1	30	30.0 ²
Үүнээс: Байнгын ажлын байр	тоо	56	3		30	30.0 ²
Улирлын чанартай ажлын байр	тоо	0	0	1	0	
4. Халдварт өвчний гаралт - бодит тоогоор	тоо	176	99	131	172	131.3
- 10000 хүнд ноогдох	тоо	26	14	19	24	128.8
5. Гэмт хэргийн гаралт - бодит тоогоор	тоо	76	100	108	107	99.1
- 10000 хүнд ноогдох ***	тоо	18	23	24	24	99.1
6. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая төгрөг	8602.9	10343.8	32344.1	6425.6	19.9
- Борлуулсан бүтээгдэхүүн	сая төгрөг	22114.5	19247.8	37874.2	23235.1	61.3

* - 2016,2017,2018 оны жилийн эцэст

**-Төрөлт, нас баралтыг ЭМГ-ын мэдээнээс авав.

*** - 18 - аас дээш насны 10000 хүнд ноогдохоор тооцов.



НЭГ. ЭРҮҮЛ МЭНД

1.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ

	Хэмжих нэгж	2019 II	2020 II	Өсөлт	
		Тоо		Хувь	
1. Амбулаторийн үзлэг	мян.хүн	62.4	72.3	9.9	115.9
2. Ор хоног	мян.хүн	18.7	24.4	5.7	130.5
3. Урьдчилан сэргийлэх тарилга	мян.хүн	1.9	1.7	-0.2	89.5
4. Эмчлүүлсэн хүний тоо	мян.хүн	2.7	3.6	0.9	133.3
5. Түргэн тусламжын дуудлага	мян.хүн	4.1	4.7	0.6	114.6
Үүнээс: алсын дуудлага	мян.хүн	0.6	0.8	0.2	133.3
6. Осол гэмтлийн өвчлөл	хүн	344	430	86	125.0
Үүнээс: нас баралт	хүн	11	13	2	118.2
7. Шинээр хяналтанд авсан жирэмсэн эх	хүн	319	312	-7	97.8
Үүнээс: эхний 3 сартайн хяналт	хүн	275	288	13	104.7
8. Амаржсан эх	хүн	213	255	42	119.7
Үүнээс: нас баралт	хүн	0	0	0	0.0
9. 1-5 хүртэл насны эндсэн хүүхэд	хүн	1	0	-1	0.0
10. 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүн	2	4	2	200.0

1.2. ТӨРӨЛТ, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар, жил бүрийн 02 сард

Сумын нэр	Амаржсан эх	Эхийн эндэгдэл	Амьд төрсөн хүүхэд	1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	1-5 хүртэл насны эндсэн хүүхэд
Тоо					
Дүн	255	0	256	4	0
Айраг					
Алтанширээ	1		1		
Даланжаргалан					
Дэлгэрэх					
Иххэт					
Мандах					
Өргөн					
Сайхандулаан					
Улаанбадрах					
Хатанбулаг				1	
Хөвсгөл	1				
Эрдэнэ					
Сайншанд	205		206	4	
Замын - Үүд	48		48		

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар



1.3. БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, төрлөөр, жил бүрийн 02 сард

Үзүүлэлт	2019 II	2020 II	Өсөлт	
	тоо	тоо	тоо	хувь
Халдварт өвчний гаралт-Бүгд	131	172	41	131.3
Вируст гепатит	3	0	-3	0.0
Сүрьеэ	9	15	6	0.0
Тэмбүү	27	20	-7	74.1
Заг хүйтэн	19	41	22	2.1 ²
Трихоминиаз	31	19	-12	61.3
Цусан суулга	6	6	0	100.0
Бусад	36	71	35	197.2

Тайлбар -²-дахин их

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар



ХОЁР. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

2.1 БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, боловсролын түвшингээр, жил бүрийн 02 сард

Боловсролын түвшингээр	2017 II	2018 II	2019 II	2020 II	2020 II 2017 II	2020 II 2019 II
	хүний тоо				хувь	
ДҮН	1 705	1 040	504	329	19.3	65.3
Үүнээс: Эмэгтэй	889	522	255	163	18.3	63.9
Магистр, доктор	7	4	0	2	28.6	0.0
Дээд боловсролтой	415	237	80	84	20.2	105.0
Тусгай дунд	180	52	31	23	12.8	74.2
Техник мэргэжлийн	166	80	29	30	18.1	103.4
Бүрэн дунд	706	578	292	160	22.7	54.8
Бүрэн бус дунд	189	59	49	24	12.7	49.0
Бага	33	10	13	3	9.1	23.1
Боловсролгүй	9	20	10	3	33.3	30.0

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

2.2 АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, жил бүрийн 02 сард

	Ажилгүй иргэдийн тоо		Ажилд орсон хүний тоо		Шинээр бүртгүүлсэн	
	2019 II	2020 II	2019 II	2020 II	2019 I-II	2020 I-II
ДҮН	504	329	47	17	1	133
Айраг	28	9	0	0	0	3
Алтанширээ	24	9	2	0	0	3
Даланжаргалан	23	8	4	0	0	2
Дэлгэрэх	15	7	1	0	0	3
Иххэт	7	8	0	1	0	2
Мандах	10	2	0	0	0	1
Өргөн	9	4	0	0	1	3
Сайхандулаан	10	13	2	0	0	2
Улаанбадрах	2	5	6	0	0	5
Хатанбулаг	4	8	4	15	0	10
Хөвсгөл	12	4	2	0	0	1
Эрдэнэ	6	7	0	0	0	6
Сайншанд	266	185	20	1	0	73
Замын - Үүд	88	60	6	0	0	19

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



2.3 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, эдийн засгийн салбарын ангилал, 2020 оны 02 сарын эцэст

Салбарын ангилал	2019 I-II	2020 I-II
	Тоо	
Бүгд	51	52
ХАА, ан агнуур, ойн аж ахуй,загас барилт		
Уул уурхай олборлох аж үйлдвэр	1	
Боловсруулах үйлдвэрлэл		
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	1	
Усны хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын	6	
Барилга		2
Бөөний ба жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар		
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	1	
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	2	
Мэдээлэл, холбоо		
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1	
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа		
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа		1
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа		1
Төрийн удирдлага, батлан хамгаалах, үйл ажиллагаа, албан	12	17
Боловсрол	10	8
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ	1	6
Урлаг, үзвэр,тоглоом наадам		5
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	16	12
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа,өрхийн		
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа		

2.4 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, ажил, мэргэжлийн ангилал, 2020 оны 02 сарын эцэст

Үзүүлэлт	2019 I-II	2020 I-II
	Тоо	
Бүгд	51	52
Менежер	1	1
Мэргэжилтэн	22	17
Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн	3	3
Контор, үйлчилгээний ажилтан	4	1
Худалдаа, үйлчилгээний ажилтан	4	11
ХАА, ой загас агнуурын ажилтан		
Үйлдвэрлэл, барилга,гар урлал,холбогдох ажил үйлчилгээний ажилтан		1
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	7	6
Энгийн ажил мэргэжил	9	1
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	1	11

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



ГУРАВ. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

3.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн 02 сард

Үзүүлэлт	2019 I-II	2020 I-II	2020 I-II 2019 I-II
	сая төгрөг		хувь
Нийгмийн даатгалын сангийн орлого	6 827.1	7 009.7	102.7
Тэтгэврийн даатгалын сан	4 297.7	4 430.9	103.1
Тэтгэмжийн даатгалын сан	487.7	499.5	102.4
Эрүүл мэндийн даатгалын сан	1 133.0	1 151.0	101.6
ҮОМШӨ*-ний даатгалын сан	712.0	728.0	102.2
Ажилгүйдлийн даатгалын сан	196.7	200.3	101.8
Нийгмийн даатгалын сангийн зарлага	8 479.7	9 558.3	112.7
Тэтгэврийн даатгалын сан	5 956.8	6 957.1	116.8
Тэтгэмжийн даатгалын сан	473.4	758.8	160.3
Эрүүл мэндийн даатгалын сан	1 416.0	1 134.0	80.1
ҮОМШӨ*-ний даатгалын сан	458.2	421.0	91.9
Ажилгүйдлийн даатгалын сан	175.3	287.4	163.9

3.2 НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 02 сард

Үзүүлэлт	2019 I-II	2020 I-II	2020 I-II 2019 I-II
	хүн		хувь
1. Нийгмийн даатгалд даатгуулагчид	16208	15626	96.4
Албан журмаар даатгуулагчид	14425	14920	103.4
Аж ахуй нэгж, байгууллага	7184	7461	103.9
Төсөвт байгууллага	7241	7459	103.0
Сайн дураар даатгуулагчид	1783	706	39.6
2. Тэтгэвэр авагчдын тоо	8436	8906	105.6
Өндөр насны тэтгэвэр	6085	6466	106.3
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	1251	1304	104.2
Тэжээгчээ алдсаны	507	506	99.8
Цэргийн тэтгэвэр	435	472	108.5
ҮОМШӨ*-ний	158	158	100.0
	сая төгрөг		
3. Олгосон тэтгэвэр	6 407.0	7 376.2	115.1
Өндөр насны тэтгэвэр	4 427.8	5 144.5	116.2
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	687.5	852.6	124.0
Тэжээгчээ алдсаны	289.9	329.7	113.7
Цэргийн тэтгэвэр	543.6	628.4	115.6
ҮОМШӨ*-ний	458.2	421.0	91.9

Тайлбар: *-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтэс



3.3 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, сумаар

Сумын нэр	2019 I-II	2020 I-II	2020 I-II 2019 I-II
	сая төгрөг		хувь
ДҮН	6827.1	7009.7	102.7
Айраг	93.9	120.1	127.9
Алтанширээ	37.6	50.1	133.2
Даланжаргалан	207.3	358.8	173.1
Дэлгэрэх	44.4	58.5	131.8
Иххэт	64.7	85.6	132.3
Мандах	44.0	62.2	141.4
Өргөн	191.3	152.8	79.9
Сайхандулаан	52.0	65.1	125.2
Улаанбадрах	32.4	60.6	187.0
Хатанбулаг	44.1	122.9	278.7
Хөвсгөл	44.0	53.6	121.8
Эрдэнэ	80.8	97.8	121.0
Сайншанд	4334.8	3839.6	88.6
Зүүнбаян баг	191.6	250.9	130.9
Замын-Үүд	1364.2	1631.1	119.6

3.4 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, сумаар

Сумын нэр	2019 I-II	2020 I-II	2020 I-II 2019 I-II
	сая төгрөг		хувь
ДҮН	8479.7	9558.3	112.7
Айраг	393.2	453.6	115.4
Алтанширээ	149.5	171.8	114.9
Даланжаргалан	281.6	464.6	165.0
Дэлгэрэх	163.8	201.9	123.3
Иххэт	281.8	316.0	112.1
Мандах	159.9	201.8	126.2
Өргөн	280.4	317.3	113.2
Сайхандулаан	117.8	147.1	124.9
Улаанбадрах	161.3	202.6	125.6
Хатанбулаг	314.7	344.4	109.4
Хөвсгөл	143.8	175.5	122.0
Эрдэнэ	266.7	330.4	123.9
Сайншанд	4077.8	4024.6	98.7
Зүүнбаян баг	302.6	378.5	125.1
Замын-Үүд	1384.8	1828.2	132.0



3.5 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 02 сарын эцэст

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2020 I-II 2019 I-II	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2020 I-II 2019 I-II
	2019 I-II	2020 I-II		2019 I-II	2020 I-II	
	тоо		хувь	сая төгрөг		хувь
НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ	18154	15920	87.7	1805.5	1779.5	98.6
1. Халамжийн тэтгэвэр	1500	1265	84.3	393.6	455.2	115.7
Ахмад настны тэтгэвэр	76	87	114.5	20.9	30.1	144.0
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр	1424	1178	82.7	372.7	425.1	114.1
2 Нөхцөлт мөнгөн тэтгэмж	963	946	98.2	121.64	160.1	131.6
Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай, ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны иргэнд олгосон тэтгэмж	905	897	99.1	113.4	151.5	20.5
Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгазан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	46	44	95.7	7.0	7.9	112.9
Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг мөн хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	10	5	50.0	0.9	0.7	74.5
Ахмад настныг гэртээ асрамжилж байгаа иргэн	2		0.0	0.3		0.0
Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн						
3. Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн дүн	200	242	121.0	69.4	93.4	134.7
16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	196	217	110.7	63.3	74.3	117.4
Байнгын асаргаа шаардлагатай 16-с дээш насны иргэн	1	11	0.0	0.06	0.7	0.0
Гурав ба түүнээс дээш тооны бага насны /14 хүртэлх насны/ хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/			0.0	0.0	0.0	0.0
2 ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмж	3	2	0.0	6.0	4.0	0.0



Хүснэгт 3.5-ийн үргэлжлэл

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2020 I-II 2019 I-II	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2020 I-II 2019 I-II
	2019 I-II	2020 I-II		2019 I-II	2020 I-II	
	тоо		хувь	мянган төгрөг	хувь	
18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн	0	1	0.0	0.0	1.2	0.0
Гэнэтийн аюул, ослын улмаас орон гэргүй болсон өрх	0	10	0.0	0.0	12.0	0.0
Хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн	0	0	0.0	0.0	0.0	0.0
Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай, 4 ба түүнээс дээш 18 хүртэлх насны хүүхэдтэй, гэр оронгүй, өрх толгойлсон иргэн	0	1	0.0	0.0	1.2	0.0
4. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардал	0	0	0.0	0	0	0.0
5. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах зардал	6254	3526	56.4	140.9	128.6	91.3
Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлтийн зарцуулалт	3250	508	15.6	39.4	31.7	80.5
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт	151	96	63.6	9.9	10.9	110.0
Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүн, сум, хорооны нийгмийн ажилтанд олгох урамшил	0		0.0	0.0		0.0
Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт	2470	2250	91.1	58.4	62.7	107.4
Банкны шимтгэл				1.1		0.0
Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмжийн зарцуулалт	383	672	175.5	32.1	23.3	72.6
6. Бусад халамжийн дүн	9237	9941	107.6	1080.0	942.2	87.2
Алдарт эхийн одонгийн тусламж	4637	4589	99.0	616.4	590.9	95.9
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	19	18	94.7	5.3	5.6	105.7
Цалинтай ээж хөтөлбөр	2311	2775	120.1	260.9	136.7	52.4
Насны хишгийн зардал	2270	2559	112.7	197.4	209.0	105.9
Өрх толгойлсон эх/эцэг хөтөлбөрийн зардал	0	0	0.0	0.0	0.0	0.0

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



ДӨРӨВ. ГЭМТ ХЭРЭГ

4.1 БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО, төрлөөр, жил бүрийн 02 сард

Хэргийн төрөл	2019 I-II	2020 I-II	зөрүү	Хэргийн бүтэц	
				2019 I-II	2020 I-II
	тоо	хувь			
Бүртгэгдсэн гэмт хэрэг - ДҮН	108	107	-1	100.0	100.0
Хүн амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	5	3	-2	4.6	2.8
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	11	1	-10	10.2	0.9
